

Зохион байгуулсан соёл, урлагийн арга хэмжээ, түүнд хамрагдагсадын тоо, үйл ажиллагааны орлого, зарцуулсан санхүүжилт, ахиц өөрчлөлт, үр дүн:



Сумын эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран Дархан бэр хүндэтгэн өргөмжлөсөн нь ураг төрөл, ахан дүүсийн залгамж холбоо батжиж бэрээ хүндэтгэн дээдлэсэн. Арга хэмжээг зохион байгуулж "ДАРХАН БЭР"

тодруулан өргөмжлөх арга хэмжээ зохион байгуулан ИХ ДАРХАН БЭР -5, ДАРХАНЫ ДАРХАН БЭР-5, ДАРХАН БЭР-25 нийт 35 дархан бэрийг тодруулан алдаршуулсан нь олны хүндэтгэл хүлээсэн ажил болсон.



Миний сэтгэлийн илгээмж аян" нь хүүхдүүд ээждээ хэлж чадаагүй сэтгэлийн сайхан үгээ уран яруу шүлэг, захидал, уран зураг, цахимаар олон төрлийн аргаар хүргэж баярлуулах боломжийг олгож өгсөн. Уг аяны ажиллагаанд 25 сурагч оролцож

шагналыг уран бүтээлийн зардлаас 25 000 зарцуулсан.

Соёлын төв нь дугуйлангийнхаа сурагчдын уран бүтээлийг сурталчилан таниулах алдаршуулах зорилгоор 2017 оны авьяаслан шилдэг сурагч Ардын болон зохиолын дууны мөнгө, хүрэл медаль Т.Цэрэнжигжидын "Сурагч насны дуулал" уран бүтээлийн тоглолт, 5-р ангийн хамт олны "Бид нэг ангийнхан" уран бүтээлийн тоглолтыг зохион байгуулан үзэгч олны хүртээл болгон ажиллав

Сумынхаа уяачдаа алдаршуулах, уяачдынхаа залгамж халааг бэлтгэх зорилготой "Даагатай хүүхдүүд" өдөрлөг зохион байгуулагдаж арга хэмжээг "Шилийн ирээдүй" ТББ, УБ хот дахь Нутгийн зөвлөлийн дарга С.Мөнхбаатар, МУСГЗ зураач П.Цэгмид болон нутгийн иргэд малчид ивээн тэтгэж ажиллав.

Үүний үр дүнд :



Өдөрлөгөөр мал аж ахуйн өв соёлыг өвлүүлж уламжлуулах, сурталчилах зорилгоор Хос даагатай хүүхэд, Шилдэг эмнэг сургагч, Даагатай малчин хүүхэд, Оны хурдан даага, Уран цоллооч хүүхдүүдийг тодоруулан шалгаруулж алдаршуулсан.



Соёлын төвийн эрхлэгч нь өдөрлөгийг угтаж ум марзий, морины цол дуудах 14 хоногийн сургалтыг соёлын төвдөө зохион байгуулж байгуулж 28 сурагч хамрагдан суралцсан Ахмад настан Маамын нэрэмжит” Уянгалаг ум марзий “ уралдаан зохион байгуулагдаж нийт 15 сурагч оролцож ур чадвараа

сорин нэрэмжит шагналын эзэд болсон.Монголын Эх орон телевизээр “Өндөршилийн даагатай хүүхдүүд” баримтат кино болон монголын нийт үзэгчдийн хүртээл болон сурталчилагдав

2018 онд зохион байгуулсан ажлыг тоон үзүүлэлтээр харуулбал:

№	Үзүүлэлт	2018 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
1	Зохион байгуулсан арга хэмжээ	97	128	131,9
2	Үүнээс Уран бүтээл	4	7	175 %
3	Үдэслэг ШОУ	28	32	114,2 %
4	Үзэгчид	6000	8658	144,3%
6	Өөрийн орлого	2000 000	2000 000	100%
7	Дугуйлан	5	5	100 %
9	Дугуйланд хамрагдагсад	55	Хүүхэд -74 Насанд хүрэгсэд -190	170,3
9	Нүүдлийн үйлчилгээ Түүнд хамрагдагсад /хэсэгчилсэн үйлчилгээ /	2	3	150 %
10	Угийн бичиг	480	272	56,6 %
11	Уралдаан тэмцээнд оролцсон байдал		4	

